

ИННОВАЦ, ТЕХНОЛОГИЙН ЛАБОРАТОРИ

Инновац, технологийн лаборатори нь эрдэм шинжилгээний ажилд шаардлагатай хэмжилтийг гүйцэтгэх, гарсан үр дүнг практикт нэвтрүүлэх, аж ахуйн нэгжүүдийн захиалгат болон гэрээт ажил гүйцэтгэх, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудад орчин үеийн аналитик аргуудаар хэмжилт, шинжилгээний ажил хийж гүйцэтгэдэг.

Түүнчлэн хүрээлэн буй орчны хөрс, ургамлын бүрхэвч дэх биологийн идэвхт элементүүд, хүнд металлуудын агуулга тархалтыг тогтоох судалгаа болон Монгол орны цахиур агуулсан түүхий эдээс сайн чанарын шил хайлуулах, шилэн бүтээгдэхүүн гарган авах ажлуудыг гүйцэтгэж байна.

Лабораторийн зорилго: Инновац, технологийн лаборатори нь хүрээлэнгийн эрдэмтдийн шинэ санаа, бүтээлийг инновац болгон хөгжүүлэх, улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах, эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийг холбох, хувь хүмүүс, албан газруудаас ирүүлсэн дээжийг шинжлэн судлах зэрэг зорилготойгоор ажиллаж байна.

Спектр анализын баг: Хот суурин газрын хөрсөнд агуулагдах биологийн идэвхт элементүүд ба хүнд металлуудын агуулгыг атомын спектроскопийн аргаар тодорхойлно. Хөрсөнд агуулагдах элементүүдийн геохимийн төлөв, орших эх үүсвэр (литоген, педоген, антропоген)-ийг олон хэмжээст статистикийн анализын аргуудаар тогтоох, хүнд металлын бохирдлын түвшинг хөрсний геохимийн үнэлгээний тоон аргуудаар үнэлэх, бохирдлын түвшний тархалтыг тогтоож, орон зайн геостатистик, интерполяц, кригингийн аргаар бохирдлын түвшний тархалтын зураглал хийж байна.

Шилний технологийн баг: Шил хайлуулах технологийн горимыг тогтоох зорилгоор төрөл бүрийн хаягдал шилнүүдийг 1000°C...1450°C-т хайлуулан, элс + шилний хольцны “шил үүсэх” процессыг судлах зорилгоор элсэн дээр хольц нэмэн хайлуулах туршилт, шил хайлуулах явцад газрын ховор элемент (CeO_2 , Nd_2O_3)-ийг хольж хайлуулах зэрэг туршилт, судалгааны ажлуудыг гүйцэтгэж байна.

Лабораторийн материаллаг бааз:

Орчин үеийн, өндөр нарийвчлалтай багажууд, Шилэн бүтээгдэхүүний лабораторийн болон хагас үйлдвэрлэлийн зориулалттай багаж, тоног төхөөрөмжүүдтэй. Үүнд:



Нил улаан туяаны спектроскопи
/IR Prestige-21



Хэт ягаан туяаны спектрофотометр/
/UV-2550/




Рентген дифрактометр /MAXima_X XRD-
7000/



Атомын шингээлтийн спектрофотометр -
shimadzu-6300c



TGA-2100D Термогравиметр



Раман спектроскопи (StellaWet-785 нм)



Дулаан тэлэлтийн коэффициентийг хэмжих багаж (PSYIII-1000)



Тунгалагийн зэрэг тодорхойлох багаж



Шилэн эдлэл хийх зуух



JFC- 151 маркийн өнгөлгөөний машин



Шил хайлуулах (XY-1700), шатаах (SX10-12) лабораторийн зуухнууд



Шил бутлагч машин

